



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 13 өдөр

Дугаар A/30

Даланзадгад

Хуваарь, чиг үүрэг батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны A/318, Эрүүл мэндийн сайдын 2021 оны A/760 тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эх барих эмэгтэйчүүдийн эмч нар анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг хариуцан ажиллах хуваарь, ажлын чиг үүргийг нэгдүгээр, хүүхдийн эмч нар анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг хариуцан ажиллах хуваарь, ажлын чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Эх, хүүхдийн тусlamж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах олон талт ажлуудыг санаачлан хэрэгжүүлж, мэргэжил арга зүйгээр ханган, Эмнэлгийн тусlamж үйлчилгээний хэлтэст тайлагнаж ажиллахыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг хариуцан ажиллаж байгаа нарийн мэргэжлийн эмч нарт даалгасугай.

3. Зөвлөх чиг үүрэг бүхий эмч нарын зохион байгуулсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, мэргэжлийн зөвлөгөө туслалцаа тогтмол авч, тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд хамтран ажиллаж, тусlamж үйлчилгээнд чанарын дэвшил гарган ажиллахыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүй, дэмжлэгт удирдлагаар ханган, урамшуулах ажлыг зохион байгуулан, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусlamж үйлчилгээний хэлтэс (Ж.Огтонбайгал)-т даалгасугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2018 оны A/17 тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Д.Энхмандах* д.ЭНХМАНДАХ

4859247751
ТУЗ1732 4859247751

My computer 2022 tushaal

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
06 дугаар сарын 13-ны өдрийн
A/30 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

I. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭМЧ НАР АНХАН ШАТНЫ
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ ХАРИУЦАН АЖИЛЛАХ ХУВААРЬ,
АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

1.1. АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Овог, нэр	Ажлын газар, албан тушаал	Утасны дугаар	Эрүүл мэндийн байгууллагын нэр
1	Б.Мөнхбат	БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмч, ерөнхий мэргэжилтэн	99539435 88539435	Энхийн хүслэн ӨЭМТ Мандал-Овоо СЭМТ
2	Д.Отгонжаргал	БОЭТ-ийн төрөх эмэгтэйчүүдийн тасгийн эрхлэгч	86064686	Шим билэг ӨЭМТ, Ноён СЭМТ
3	Ө.Батцэцэг	БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч	88058104	Гурван тэс СЭМТ, Ханхонгор СЭМТ
4	С.Шинэсар	БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч	88027804	Манлай СЭМТ Баяндалай СЭМТ
5	Б.Сэлэнгэ	БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч	86085507	Цогцэций СЭМТ, Цогт-Овоо СЭМТ
6	Б.Цэцэгбадам	БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч	88368020	Өнө-Орших ӨЭМТ, Хүрмэн СЭМТ
8	Б.Батчимэг	БОЭТ-ийн Өсвөр үеийн кабинетын эмч	88601242	Номгон СЭМТ
9	Д.Өлзийсайхан	Ханбогд СЭМТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч	89242399	Ханбогд СЭМТ
10	Э.Дөлгөөн	Ханбогд СЭМТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч	88550955	Баян-Овоо СЭМТ
11	Б.Долгормаа	Булган СЭМТ-ийн дарга, эх барих эмэгтэйчүүдийн эмч	88875667	Булган СЭМТ
12	Д.Алтансүх	Сэврэй СЭМТ-ийн дарга, эх барих эмэгтэйчүүдийн эмч	88709986	Сэврэй СЭМТ

1.2.АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

- 1.2.1 Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгааг бодитой, шинэчлэн гаргуулж дүгнэлт хийх
- 1.2.2 Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусlamж үйлчилгээний чиглэлээр мөрдөгдөж буй стандарт, журам, заавар, тушаалын хэрэгжилтэд хяналт тавих
- 1.2.3 Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусlamж, үйлчилгээний байдалтай танилцах, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх
- 1.2.4 Мэргэжлийн чиглэлээр ажлын байрны сургалт зохион байгуулах
- 1.2.5 Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусlamжийн зохион байгуулалтын болон мэргэжлийн тусlamжийг үзүүлэх
- 1.2.6 Эх барих, эмэгтэйчүүд, нярайн нэн шаардлагатай болон яаралтай тусlamжийн байнгын бэлэн байдал, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн хангамж, хүний нөөцийн хүрэлцээ, чадавхыг үнэлж, Эрүүл мэндийн газрын холбогдох мэргэжилтэнд танилцуулж, асуудлыг шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- 1.2.7 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц тусlamж, үйлчилгээ (үр хөндөлт, гэр бүл төлөвлөлт, БЗДХ, өсвөр үе, цэвэршилтийн нас)-ний байдалтай танилцах, зөвлөгөө өгөх
- 1.2.8 Хариуцсан анхан шатны эрүүл мэндийн төвийн жирэмсний хяналт хариуцсан эмч, эх баригчтай байнгын уялдаа холбоотой ажиллаж зөвлөгөө өгөх
- 1.2.9 Үйлчлүүлэгчийг дараагийн шатлалд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд зөвлөгөө зөвлөмжөөр хангаж, дэмжлэг үзүүлэх
- 1.2.10 Эмч, эх баригч нарт утсаар болон цахимаар зөвлөгөө өгөх
- 1.2.11 Хариуцсан сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тусlamж үйлчилгээг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын тайланг бүтэн жилээр бичиж, Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamж үйлчилгээний хэлтэст жил бүрийн 12 сарын 05-ны өдрийн дотор ирүүлж байх

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
06 дугаар сарын 13-ны өдрийн
A/30 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

II. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮҮХДИЙН ЭМЧ НАР АНХАН ШАТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫГ ХАРИУЦАН АЖИЛЛАХ ХУВААРЬ, АЖЛЫН ЧИГҮҮРЭГ

2.1 АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Овог, нэр	Ажлын газар, албан тушаал	Утасны дугаар	Эрүүл мэндийн байгууллагын нэр
1	Т.Оюундүү	БОЭТ-ийн хүүхдийн зөвлөх эмч, ерөнхий мэргэжилтэн	99100285	Мандал-Овоо СЭМТ
2	Ц.Мөнхцэцэг	БОЭТ-ийн хүүхдийн тасгийн эрхлэгч	88407289	Энхийн хүслэн ӨЭМТ
3	Ц.Нармандах	БОЭТ-ийн хүүхдийн эмч	88170919	Булган СЭМТ
4	С.Насантогтох	БОЭТ-ийн хүүхдийн эмч	86660074	Ханхонгор СЭМТ
5	Д.Саранчимэг	БОЭТ-ийн хүүхдийн эмч	88562159	Цогт-Овоо СЭМТ
6	Б.Одцэцэг	БОЭТ-ийн нярайн тасгийн эрхлэгч	88040578	Номгон СЭМТ
7	Э.Ренчин	БОЭТ-ийн нярайн эмч	88464499	Сэврэй СЭМТ
8	Ж.Мягмарцэрэн	Баяндалай СЭМТ-ийн дарга, хүүхдийн их эмч	89897089	Баяндалай СЭМТ
9	С.Бэхтуяа	Баян-Овоо СЭМТ-ийн хүүхдийн эмч	88338134	Баян-Овоо СЭМТ
10	У.Нямсүрэн	Гурвантэс СЭМТ-ийн дарга, хүүхдийн эмч	96119019	Гурвантэс СЭМТ
11	Д.Уламбаяр	Манлай СЭМТ-ийн дарга, хүүхдийн эмч	88024435	Манлай СЭМТ
12	Ц.Бурмаа	Ноён СЭМТ-ийн хүүхдийн эмч	96061736	Ноён СЭМТ
13	Ж.Наранцэцэг Н.Наранцэцэг	Ханбогд СЭМТ-ийн хүүхдийн эмч	89991329 89133155	Ханбогд СЭМТ
14	Б.Туул	Хүрмэн СЭМТ-ийн дарга, хүүхдийн эмч	88079104	Хүрмэн СЭМТ
15	С.Алтанцэцэг	Цогтцэций СЭМТ-ийн хүүхдийн эмч	86532255	Цогтцэций СЭМТ
16	Б.Бат-Өлзий	Шим билэг ӨЭМТ-ийн хүүхдийн эмч	88085108	Шим билэг ӨЭМТ
17	Ж.Мөнхцэцэг	Өнө-Орших ӨЭМТ-ийн дарга, хүүхдийн эмч	88323086	Өнө-Орших ӨЭМТ

2.2 АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

2.2.1. 0-5 настай хүүхдийн судалгааг шинэчлэн, бодитой гаргуулж, судалгаанд тулгуурлан, хяналтыг сайжруулан ажиллах

2.2.2. Хүүхэд, нярайн тусlamж үйлчилгээний чиглэлээр мөрдөгдөж буй стандарт, журам, заавар, тушаалын хэрэгжилтэд хяналт тавих

2.2.3. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн хүүхэд, нярай, өсвөр үеийн тусlamж үйлчилгээний байдалтай танилцах, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх

2.2.4. Мэргэжлийн чиглэлээр ажлын байрны сургалт зохион байгуулах

2.2.5. Хүүхэд, нярайн тусlamжийн зохион байгуулалтын болон мэргэжлийн тусlamжийг үзүүлэх

2.2.6. ХӨЦМ, эрэмбэлэн ангилал, яаралтай тусlamж болон нярайн нэн шаардлагатай тусlamжийн байнгын бэлэн байдал, эм эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн хангамж, хүний нөөцийн хүрэлцээ, чадавхыг үнэлж, Эрүүл мэндийн газрын холбогдох мэргэжилтэнд танилцуулж, асуудлыг шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлэх

2.2.7. Анхан шатны эрүүл мэндийн төвийн эмч, хүүхдийн хяналт хариуцсан эмч нартай байнгын уялдаа холбоотой ажиллаж, утсаар болон цахимаар зөвлөгөө өгөх

2.2.8. Дараагийн шаталын тусlamж үйлчилгээ шаардлагатай хүүхэд, нярайг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд зөвлөгөө зөвлөмжөөр хангаж, дэмжлэг үзүүлэх

2.2.9. Хариуцсан сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тусlamж үйлчилгээг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын тайланг бүтэн жилээр бичиж, Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamж үйлчилгээний хэлтэст жил бүрийн 12 сарын 05-ны өдрийн дотор ирүүлж байх